

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-39
	1. Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.04.05-өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	7-39

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн хуралдааны
товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 07 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Т.Аубакир, Д.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Б.Бейсен, Н.Учрал;

Чөлөөтэй: Т.Аюурсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Чинбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баделхан, Б.Жаргалмаа, Ш.Раднаасэд, Ч.Ундрэм;

Тасалсан: Б.Энх-Амгалан;

Хоцорсон: С.Батболд – 26 минут, Б.Дэлгэрсайхан – 14 минут, Г.Мөнхцэцэг – 6 минут, С.Одонтуяа – 14 минут, Д.Өнөрболор – 10 минут, Д.Сарангэрэл – 6 минут, Ж.Сүхбаатар – 5 минут, Ч.Хүрэлбаатар – 17 минут, О.Цогтгэрэл – 7 минут, Ц.Цэрэнпунцаг – 5 минут, Б.Энхбаяр – 39 минут, Н.Энхболд – 16 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагаас ирүүлсэн албан бичгийг уншиж танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа үг хэлэв.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүдийн ширээн дээр “Хүнсний үнээр түр аргацаах бодлого Хөгжлийн банк, ЖДҮ-ийн түүхийг давтах вий!”, “ПиАр-таа биш бодлогодоо АНХААР!”, “КОВИД-ын хуулийг

ЦУЦАЛ!”, “Чөлөөт эдийн засгийг ЧӨДӨРЛӨХ-өө боль!”, “МАН 6 дахь жилдээ засаглаж байна. Өнөөгийн байгаа байдал АХИАД л Ард түмэн, Ардчилсан нам хоёрын буруу ЮУ?” гэсэн бичиг бүхий лоозонг байрлуулсан байв.

Нэг.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.04.05-өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын дарга Б.Баярдаваа нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат нар танилцуулав.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэв. /15:30/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэгт 30 минутын завсарлага өгөв.

Хуралдаан 23 минут үргэлжилж, 15 цаг 30 минутад түр завсарлаж, 16 цаг 02 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэж, чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлэв.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, С.Бямбацогт нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа хариулж, тайлбар хийв.

Төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Т.Доржханд, Б.Пүрэвдорж, Ч.Ундрэм, Ч.Хүрэлбаатар, С.Чинзориг, Б.Чойжилсүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн гарчгийн “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэснийг хасах. Энэ саналтай холбогдуулан төслийн 1.1 дэх хэсэгт заасан хуулийн зорилгод байгаагаас бусад төслийн зүйл, хэсэг, заалтад байгаа “олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Туваан нар дэмжсэн, дэмжээгүй үг хэлэв.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 22
Бүгд: 55
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5.1 дэх хэсгийн “банктай хамтран” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 22
Бүгд: 55
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “банкаар дамжуулан олгох” гэснийг “банкны эх үүсвэрээр олгох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 23
Бүгд: 54
57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5.1.2 дахь заалтын “хөнгөлөлттэй санхүүжилтийг банкаар дамжуулан” гэснийг “санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 21
Бүгд: 54

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5.1.3 дахь заалтыг “санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан энэ хуулийн 3.2.1-д заасан бараа, бүтээгдэхүүний импортод шаардлагатай гадаад валютыг ханшийн эрсдэлийг бууруулж импортлогчид нийлүүлэх бөгөөд банк энэ эх үүсвэрээр ашиг олох зорилгоор арилжаа хийхийг хориглох;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн, Х.Болорчулуун нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 20
Бүгд: 55

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6.1.2 дахь заалтын “жилийн батлагдсан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх замаар шийдвэрлэх” гэснийг “тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, С.Бямбацогт нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 22
Бүгд: 53

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 19
Бүгд: 54

64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6.1.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 21
Бүгд: 54
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6.1.1, 7.1.1 дэх заалтын “бүтээгдэхүүний” гэсний дараа “үнийн өсөлт,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 24
Бүгд: 54
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Хууль, тогтоолын хүчин төгөлдөр болох хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 25
Бүгд: 54
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчигт “төрлийн” гэсний дараа “зарим” гэж, 5.1, 6.1, 7.1, 8.1 дэх хэсгийн “хэрэгжүүлнэ,” гэсний өмнө “авч” гэж, 5.1 дэх хэсгийн “гол” гэсний өмнө “энэ хуульд заасан” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 3.1 дэх хэсгийн “эдгээр бүтээгдэхүүнтэй хамаатай” гэснийг “эдгээртэй холбогдсон” гэж, 3.2 дахь хэсгийн “доор дурдсан” гэснийг “заасан гол нэр төрлийн зарим” гэж, мөн хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүнд дараах бараа, бүтээгдэхүүн” гэж, 7, 8 дугаар зүйлийн гарчгийн “байгууллагын” гэснийг “байгууллагаас” гэж, 8.1.1, 8.1.2 дахь заалтын “хуульд заасан зохицуулалтад хамрагдсан” гэснийг “хуулийн 3.2.2, 3.2.3-т заасан” гэж, 8.1.1 дэх заалтын “хүнсний хангамж,” гэснийг “хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, хангамж” гэж, 7.1.2, 8.1.2 дахь заалтын “мөрдүүлэх” гэснийг “, биелэлтийг ханган ажиллах” гэж, 6.1.6 дахь заалтын “мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.” гэснийг “, биелэлтийг хангуулан ажиллах” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн зүйл, хэсэг, заалт хасагдсантай холбогдуулан дугаарлалтыг өөрчлөх болон төслийн агуулгыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх гэсэн найруулгын саналуудыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 21
Бүгд: 54
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 00 минутад хэлэлцэж дуусав

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 25 минут үргэлжилж, ирвэл зохих 76 гишүүнээс 61 гишүүн хүрэлцэн ирж, 80.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Ирц танилцуулъя. Орон нутагт томилолттой болон өвчтэй, чөлөөтэй 11 гишүүн байна. Ирвэл зохих 65 гишүүнээс 39 гишүүн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна.

Ийм учраас Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа албан бичиг ирүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын энэ долоо хоногийн чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудал дээр Олон улсын хямралт нөхцөл байдлын үед төсвийн хэмнэлтийн горимд шилжих талаар авах зарим арга хэмжээний тухай хуулийн төслийн талаар үг хэлэх хүсэлтээ хүргүүлж байна.

Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа үг хэлнэ.

Ш.Адьшаа: Та бүгдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Энэ хүнс, өргөн хэрэглээний бараа, шатахууны хомсдлоос хамгаалах энэ хуулийн төслийг хэлэлцэж байгаатай холбогдуулж өөрийн байр сууриа илэрхийлье гэж бодсон юм.

Эдийн засгийн хямралаас эх орноо хамгаалах асуудал өнөөдөр хамгийн чухал байна. Ард иргэдээ хамгаалах асуудал хамгийн чухал байна.

Валютын нөөцийг бүрдүүлэх, энэ хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал хамгийн чухал байна. Энэ дээр манай Улсын Их Хурал, Засгийн газар тодорхой хууль зайлшгүй оруулж ирэх шаардлагатай байна.

Өнөөдөр энэ уул уурхайн баялгийг аваад гадаадад гаргаж байгаа Оюу Толгой, Мон-Энко мэтийн компаниуд өнөөдөр Монгол Улсад авсан ашигт малтмалынхаа үнийг оруулж ирдэггүй. Зөвхөн урсгал зардлаа Монголын банкаар дамжуулж оруулж ирж байна.

Гэтэл энэ Валютын зохицуулалтын тухай хуулийг яаралтай горимоор оруулж ирж, энэ Монголын банкаар дамжуулж, Монгол Улсад бүртгэлтэй банк, санхүүгийн байгууллагаар дамжуулж валютын урсгалыг татаж оруулж байж бид өнөөдөр энэ валютын хомсдлоос гарах боломж байгаа. Үүнийг оруулж ирэх цаг үе нь өнөөдөр болсон байна.

Нөгөө талаас Монгол Улсын арилжааны банкнуудад гаднын Оюу Толгой мэтийн компаниуд итгэдэггүй гэж ярьдаг гэсэн. Гэтэл өнөөдөр бид Монголын арилжааны банкууд итгэдэггүй юм бол гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх хууль, эрх зүйн орчныг яаралтай бүрдүүлье.

Энэ хууль, эрх зүйн орчныг бүрдүүсэн үндсэн дээр энэ уул уурхайн компаниар дамжиж гадагшаа гарч байгаа валютын урсгал өнөөдөр Монгол Улсад орж ирэх ийм хууль, эрх зүйн орчин бүрдэх боломж байгаа гэдгийг зориуд тэмдэглэн хэлж, энэ талаар арга хэмжээ авахыг би өнөөдөр Улсын Их Хурал дахь олонхын бүлэгт уриалж байна. Уриалж байна.

Ийм хууль, эрх зүйн арга хэмжээ авахгүйгээр зөвхөн энд нэг дотоодын гурил, хүнс, шатахууны хомсдол гэх мэт ийм зүйл дээр бид өнөөдөр төсвийн хөрөнгийг татаж төвлөрүүлснээр бид энэ эрсдэлээс гарах ямар ч боломж байхгүй шүү.

Энэ дээр Та бүхэн өнөөдөр улс эх орныхоо эрх ашгийн өмнөөс энэ гаднын Оюу Толгой мэтийн компаниудтай хэлэлцээр хийж, энэ хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, Монгол Улсын эдийн засгийг аврах, валютын хомсдлоос аврах гарц, шийдлийг яаралтай хэлэлцүүлж шийдвэрлэх ийм саналыг би өнөөдөр Улсын Их Хуралд оруулж байна.

Үүнийг Та бүхэн хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Олон улсын хямралт нөхцөл байдалтай холбоотой төсвийн тодотгол хийх асуудал. Монгол Ардын намын бүлэг шийдвэрлээд ажлын хэсгүүд байгуулагдаад ажиллаж байгаа. Тэр үед Ш.Адьяаа гишүүн энэ саналуудаа тусгаад явж болно.

Одоо хэлэлцэх асуудалд орно.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны дарга Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний нь үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн байгаа.

Улсын Их Хурлын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 48 дугаар захирамжаар Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах, үүсээд буй хямралт нөхцөл байдлыг шийдвэрлэх, бодлогын шийдэл гаргах, хэмнэлтийн горимд шилжих чиглэлээр төсөвт тодотгол хийх, холбогдох хууль, тогтоол, хөтөлбөрт өөрчлөлт оруулах, төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа ахалж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Т.Доржханд, Б.Пүрэвдорж, Ч.Ундрам, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажилласан байгаа.

Байнгын хороо 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж дараах санал дүгнэлтийг гарган Та бүхэндээ танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал нэг бүрийг хэлэлцэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжлээ.

Тухайлбал, хуулийн төслийн гарчгийг “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэснийг хасах, төслийн 6.1.3, 6.1.5 дахь заалтууд нь Улсын Их Хурлын эрх мэдэлд хамаарах асуудал тул төслөөс хасах, 5.1.1 дэх заалтаар “банкаар дамжуулан олгох” гэснийг “банкны эх үүсвэрээр олгох” гэж, 5.1.2 дахь заалтын “хөнгөлөлттэй санхүүжилтийг банкаар дамжуулна” гэснийг “санхүүжилтээр репо арилжааны нөхцөлөөр банканд” гэж тус тус өөрчлөх. Хуулийг дагаж мөрдөх хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэх зэрэг зарчмын зөрүүтэй 10 санал болон төслийн агуулгыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн найруулгын шинжтэй засваруудыг хийх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн байгаа.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Би энд бас манай энэ хуулийн төсөл манай **“D-Parliament”** аппликэйшн дээр тавигдсан. Нийтдээ 1363 иргэн танилцаж, 140 иргэн энэ хуулийг дагасан байна.

Нийтдээ 25 коммент ирсэн байна. Манай ажлын хэсэг, Байнгын хорооны гишүүдэд иргэдээс ирсэн саналуудыг бас нэлээн нухацтай ярилцаж хэлэлцсэн байгаа.

Тэгээд би саналаа ирүүлсэн иргэдэд баярласан талархсанаа илэрхийлье.

Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд ийнхүү **“D-Parliament”** аппликэйшнаар дамжуулан Та бүхэн саналаа ирүүлж, ажлын хэсэг дээр Та бүхний санал чухал үүрэг гүйцэтгэж байгааг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Ингээд Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Баярлалаа. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Дашдондогийн Ганбат танилцуулна.

Д.Ганбат: Улсын Их Хурлын дарга аа, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор Улсын Их Хуралд Ардчилсан намаас дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсад хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляц 2022 оны 02 дугаар сард улсын хэмжээнд жилийн 14.2 хувь, Улаанбаатар хотод 15.5 хувь болж, зорилтот төвшнөөс 2-оос 3 дахин нэмэгдсэн байна.

Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өдөр ирэх бүр өсөж, орлого нь хумигдсан ард иргэдийн амьдралд маш хүндээр нөлөөлж байна.

Сүүлийн хоёрхон сарын хугацаанд америк долларын ханш 12-оос 15 хувиар чангарч, олдоц нь эрс багасаж, бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж эхэллээ.

Валютын ханш нь улс орны эдийн засгийн суурь үзүүлэлт, төр засгийн хэрэгжүүлж буй бодлогын толь нь байдаг. Манай зах зээлд валютын нөөц хомстсон нь өнгөрсөн хугацаанд экспортоо хийж чадаагүйтэй холбоотой.

Энэ нь Монголын төр хийх ажилдаа түүртэж, хийхгүй байна гэж дүгнэх хангалттай жишээ юм. Үүсээд байгаа нөхцөл байдлыг судалж, бодит үнэлэлт, дүгнэлт өгч, шийдлээ гаргаж танилцуулахын оронд эрх баригчдаас дутуу дулимаг боловсруулсан түүхий хууль Улсын Их Хуралд оруулж ирлээ.

Энэ нь манай нийгэмд үүссэн нөхцөл байдлыг шийдэж буй мэт дүр эсгэх, эсвэл хариуцлагаас зугтаж байгаа нэг хэлбэр төдий юм. Инфляц буюу үнийн өсөлт дунд, урт хугацаанд хэрэгжүүлж буй эрх баригчдын бодлогын алдааны тусгал байдаг.

Үнийн өсөлтөд нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйл болох тээвэр, ложисткийн түгжрэл, түүнийг дагасан тээврийн өндөр зардал, Украин, Оросын Холбооны Улс хооронд өрнөсөн дайн, түүнтэй холбоотой түүхий эд, газрын тосны хямрал зэрэг гадаад шалтгаан бий.

Мөн дотоод шалтгаан хамгийн жинтэй нөлөө үзүүлдэг гэдгийг мартаж болохгүй. Эрх баригчдын Улсын Их Хуралд өргөн барьсан бодлого, Засгийн газрын хэрэгжүүлж буй ажлууд үнийн өсөлтийг өдөөж буй талаар Улсын Их

Хурал дахь Ардчилсан намын бүлгээс удаа дараа сануулж ирсэн. Тус бүлгийн гишүүд ч Улсын Их Хурлын индэр дээрээс хангалттай анхааруулж байсан.

Эдийн засгийн нэн хүнд, хямралтай он жилүүдэд Ардчилсан нам хоёр ч удаа засгийн эрх барихдаа үнэ ханшийг буулгах олон арга хэрэгслүүд ашиглаж ирсэн туршлага бий.

Үнэ тогтворжуулах, ипотекийн хөтөлбөрүүд үүний нэг жишээ билээ. Гэхдээ зах зээлд мөнгө хэвлэж оруулж болохгүй. Мөн татвар төлөгчдийн мөнгөнөөс хумслахгүйгээр хэрэгжүүлэх учиртай юм.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн нэрнээс нь уншвал мах, гурилын нөөц бүрдүүлэх замаар үнийн өсөлт буюу инфляц буудах юм байна гэж ойлгогдохоор байна.

Монгол Улсын гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг зөвхөн гурван бүтээгдэхүүнээр тооцдоггүй. Тус хуулийн зорилго, зорилт нь тодорхойгүй, хүрэх үр дүн нь бүрхэг, тооцоо судалгаа тааруу, санхүүжилтийн эх үүсвэр, хэмжээ нь тодорхойгүй, ардчилал, зах зээлийн нийгэмд шилжээд 30 орчим жил болсон хэрнээ санхүүгийн гадагшаа гарах урсгалаа боомилох, хариуцлага, хяналтын механизмыг орхигдуулсан гээд тоочвол олон алдаа мадаг байна.

Эдийн засаг хүндэрсэн, бараа, бүтээгдэхүүний үнэ огцом өсөж, үндэсний валютын ханш суларсан энэ байдлыг цогц бодлогоор тодорхой хугацаанд залруулах боломжтой.

Хамгийн эхэнд тээвэр, логистикийн асуудалдаа анхаарал хандуулах учиртай юм. Зөвхөн тээврийн гацаа, өндөр зардлыг буулгаж байж инфляцыг бууруулах боломж гарч ирнэ.

Мөн экспортод гаргадаг түүхий эдийн урсгалыг нэн даруй сэргээх хэрэгтэй байна. Өнөөдөр түүхий эдийн хувьд **“супер циклийн үе”** гэж яригдаж байна шүү дээ.

Ингэвэл валютын орох урсгал нэмэгдэн ханшийн асуудал шийдвэрлэх боломж үүснэ. Үнэ буулгах болон ханшийн асуудлыг ганцхан хууль гаргаад шийдсэн тохиолдолд хаа ч байхгүй. Дэлхийд ч байхгүй. Харин муу хууль эсрэгээрээ хямралыг улам гааруулж даамжруулах магадлалтай гэдгийг анхааруулъя.

Та бүхний шийдвэрлэх ёстой асуудал ийм энгийн, маш тодорхой байтал яаруу сандруу түүхий хууль өргөн барих замаар үүссэн нөхцөл

байдлыг шийдэж буй дүр эсгэх, хариуцлагаас зугтах бултах гэж оролдох шаардлагагүй.

Газрын тосны бүтээгдэхүүний хувьд хойд хөрштэйгөө тохирч чадвал Энэтхэг Улс шиг зах зээлийн үнээс ч хямдаар авч болж байна. Рубль оролцуулах, форвард хэлэлцээ хийх зэрэг олон арга замыг л эрэлхийлж хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа ам хэлээ олдог бай гэж Монголын сонгогчид, Монголын ард иргэд Та бүхнийг олонх болгосон.

Ардчилсан намын бүлэг ард иргэдийнхээ нэгэн адил Та бүхнээс “ажлаа хий” гэж хүсэж байна.

Харин Улсын Их Хурал дээр иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэх, эм тарианы болон эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зэрэг чухал асуудлаа эрэмбэлээд оруулаад ир.

Гоё ганган уриа лоозонд мөнгө цацаж, элдэв амлалтаар, иргэдийн тархи угаахын оронд хямрал далласан бодлогоо нэн даруй засаж өөрчлөх, үнэ ханш тогтворжуулах бодитой ажил хийхийг Та бүхнээс хүсэж, шаардаж байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15.1-д нам, эвслийн бүлэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33.1.4-т заасны дагуу завсарлага авах эрхтэй.

Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байна гэж заасны дагуу энэ хуулиа илүү боловсронгуй болгож, илүү бид бүхэнд сайн тайлбарлаж, ард түмэндээ ойлгуулахад цаг хугацаа хэрэгтэй гэж үзэж байна.

Ийм учраас Ардчилсан намын бүлэг ажлын 5 хоногийн завсарлага авч байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль дээр завсарлага өгөх дэг хараадах.

Өглөө Үндсэн хуулийн танхимд билүү. Та бүхний зохион байгуулж байгаа хэлэлцүүлэг дээр харсан. Завсарлага авах асуудал ямар ч байсан тавь. Тэр иргэдээс. Тэгээд 30 минутын завсарлага өгнө биз гэж ярьж байхыг би бас сонссон. Нөгөө нээлттэй явсан юм чинь.

Тэгээд энэ асуудал нэн яаралтай хэлэлцэх ёстой асуудал. Нэн яаралтай хэлэлцэхээр захирамж гаргасан.

Цаг үеийн байдал, олон улсын хямралт нөхцөл байдал амаргүй байна. Цар тахал КОВИД-ын улмаас өмнөд хөршид ч гэсэн тэг КОВИД-ын дэглэм, зарчим баримталж байгаа. Хойд хөрш олон улсын хориг санкцад орсонтой холбоотойгоор дунд нь далайд гарцгүй Монгол Улсын хувьд энэ тээвэр, бүтээгдэхүүний ложистик, нийлүүлэлтийн үнийн асуудлууд бий.

Ийм учраас 30 минутын завсарлага өгч байна. /алх цохив/

Энэ хуулийнхаа анхны хэлэлцүүлгийг одоо явуулаад. Энэ дээр чинь олон чухал саналууд гарч байгаа. Анхны хэлэлцүүлгүүдээ явуулах шаардлагатай байгаа.

Тэгэхээр анхны хэлэлцүүлгийнхээ саналын томъёоллуудтай Та бүхэн танилцаарай. Өнөөдөр бас үйлдвэрлэгчидтэй уулзаж, үнэ болох боломжийн талаар бид ярилцсан. Энэ “**D-Parliament**” дээр энэ ирсэн 51 санал дотор үндэсний үйлдвэрлэгчдээс үнэ бууруулах боломжийн талаар ярилцаа ч гэсэн. Мах, гурилынхантай уулзлаа. Хууль тусгах саналыг нь авлаа. Тэгээд ажил хэрэгч байдлаар хандаад энэ хуулиа яаралтай батлах хэрэгтэй байна.

Хаврын тариалалтыг өргөн хэмжээнд зохион байгуулах шаардлагатай байна. Дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Д.Ганбат дарга ийм чухал асуудал дээр ингэж удаашруулалгүй завсарлагаа татаад авчихаач ээ. 30 минут хүлээж байснаас. Завсарлагаа татчих. Яах вэ, татаж болно шүү дээ. Гаргасан саналаа хэзээ ч татаж болно.

Тэгээд Д.Ганбат гишүүнээс бусад нь гарахгүй байна шүү дээ, энэ чинь. Тэгэхээр бүлэг гэж үзэх. Энэ хямралт нөхцөл байдлын үед бол бид нар бас хамтын хүчээр давмаар байх юм.

Ардчилсан намын бүлгийн дэд дарга Н.Ганибал гишүүн завсарлагаа татаад авчих. Тэгэх үү.

Даргын дэргэдэх зөвлөлөөр коллектив, нөгөө хурлын шийдвэрээр л хэлэлцэх асуудал, дэг, энэ бүх асуудал шийдэгдэж байдаг. Түүнээс бие даагаад л.

Наянтайн Ганибал гишүүн.

16.00 цаг хүртэл завсарлага өглөө. 16.00 цагт эргэж хуралдъя. Ирц энэ хэвээрээ үлдэж байна. Завсарлага өгсөн учраас өдрийн ирцээрээ явна. 16.00 цагаас асуулт, хариултаар эхэлнэ.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Завсарлагын хугацаа дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлье.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн, тэр дотроо шатахууны үнийг тогтворжуулах асуудал бол нэг хоногийн өмнө ч гэсэн шийдэгдэж байвал сайн байна гэж байгаа.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын дарга Баярсайханы Баярдаваа. Сангийн яамныхныг дуудъя. Болдын Жавхлан Сангийн сайд.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 11 саналаар санал хураалт явуулна.

Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Эрхэм гишүүн Салдангийн Одонтуяа.

С.Одонтуяа: Тэгэхээр сая Ардчилсан нам завсарлага авна гэсэн чинь их шоолж байна л даа. Ард түмэн та нарыг шоолж байна шүү дээ. Талбай дээрээ зогсчихсон залуучууд.

Монгол Ардын нам ажлаа хийж чадахгүй байна. Ер нь ажлаа хийдэг юм уу. Ажлаа хийгээч гэж байна шүү дээ.

Бид нар ичих биш та нар ичих ёстой байхгүй юу. Тэгээд бөөнөөрөө суучхаад бүгдээрээ даапалаад 65-уулаа. Та нарын бусад улс орнуудаас ичээч. Бусад улс орнууд чинь адилхан л КОВИД-ын нөхцөл байдалд орсон уу, орсон. Олон улсын хүнд байдалд орсон уу орсон. Гэтэл эдийн засаг нь өссөн орнууд зөндөө байна. Ард иргэд нь байна. Жишээлэхэд, Чили, Уругвай улсууд тэр 22 мянган километрийн цаанаас зэсийн баяжмалаа Хятад руу зөөгөөд болоод байна. Манайх 30 боомттой хиллэж байгаа хэрнээ өнөөдөр 200 километр давуулаад нүүрсээ ч өгч чадахгүй байна.

Тэгэхээр ийм арчаагүй байдлаа Ардчилсан нам руу чихэх хэрэг байхгүй. Эргээд ард түмнээс Та нарыг би ичээсэй л гэж хэлмээр байна. Та нар хоёр удаа Улсын Их Хуралд 65-уулаа байгаа. Засаглаж байгаа. Тэгээд ингэж хэтэрхий ингэж битгий даапаалж бай.

Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой ярих юм байна. Энэ “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэдгийг хасъя гэдэг санал туйлын зөв. Энэ бол ихэнх гишүүд тэгж үзэж байгаа юм байна. Энэ бол өөрсдийн хариуцлагагүй байдлаас үүсэж байгаа юм зөндөө байгаа шүү.

Асуулт байна. 2012-2016 онд энэ Үнэ тогтворжуулах Ардчилсан намын хөтөлбөрийг шүүмжлээд л жигтэйхэн юм болсон. Энэ чинь харин 99 хувийн эргэн төлөлттэй байсан юм. Арилжааны банкнуудаар хэрэгжсэн юм.

Тэгэхээр энэ хөтөлбөрөөс ер нь яг юугаараа ялгаатай юм бэ? Энэ оруулж ирж байгаа хөтөлбөр чинь. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, хуулийн чинь нэр нь “сөрөг үр дагаврыг бууруулах” гэж байна. Би бол энэ “үнэ тогтворжуулахыг нь” хараад байна. “Сөрөг байдлыг бууруулахыг” ерөөсөө олж харахгүй байна. Орлого олох нэг ч заалт алга. Экспортыг нэмэгдүүлэх олигтой санал алга. Ажлын байр нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжээ дэмжих санал алга. Яах вэ, хэдэн тэр мах, гурил тойрсон хэдэн компаниуд дэмжигдэх магадлалтай.

Тэгэхээр төр бизнес хийнэ л гээд байдаг. Зүгээр энэ аж ахуйн нэгжүүдээ л ажилтай болгох юм нээж өг л дөө. Одоо надад дээр энэ миний ширээн дээр байна. Надтай эмэгтэйчүүд бичил бизнес хийж байгаа эмэгтэйчүүд уулзаж байна. 10 сая төгрөгийн зээл авахад хоногт 366 мянган төгрөг хоногийн хүү төлж байна гээд. Бид амьдармаар байна, ажил хиймээр байна, улсдаа татвар төлмөөр байна. Бид нарт энэ хөнгөлөлттэй зээл чинь олдохгүй байна гэж байна. Энэ мэтчилэн ажлаа хийе гэсэн бичил бизнесийг яагаад дэмжиж болдоггүй юм.

Тэр 5 их наядын хөтөлбөрийн чинь үр дүн хаана байна? Тайлагнаагүй. 10 их наядын хөтөлбөрийн үр дүн хаана байна? Тайлагнаагүй.

Уг нь бол тэр хоёр хөтөлбөр чинь хямралын үед хэрэгжээд одоо эдийн засгийн өсөлтөө бид яриад сууж байх ёстой ийм цаг үе байна. Ээжүүд ажил хиймээр байна. Цэцэрлэг нь алга, ясли нь алга. Тэр хүүхэд харах үйлчилгээг нь яагаад ингээд хаагаад байдаг юм. Тэрийг нь олигтойхон нээгээд өг л дөө. 7, 8 сард ч гэсэн ажиллуулъя л даа. Цэцэрлэг, тэр хүүхэд харах үйлчилгээг нь. Ээжүүд ажил хиймээр байна, улсдаа татвар төлмөөр байна гэж байна.

Тэгэхээр энэ мэтчилэн энэ эдийн засгийн реформ, орлого олох зүйл чинь алга. Экспортыг нэмэгдүүлэх нэг зүйл ч алга байна.

Хоёрдугаар асуултад нэг ийм зүйл байна. Одоо яг хэдэн төгрөгийг тэр махад нь өгөх гээд байгаа юм, юунд нь өгөх гээд байгаа юм. Ямар ч тоо алга, хугацаа ч алга. Өмнө нь бид “Мах хөтөлбөр”-т хэчнээн тэрбум “Гурил хөтөлбөр”-т хэчнээн гэж гаргаж байсан. Тэгэхээр ямар ч тоо байхгүй.

Тэгэхээр та нар нэг хязгааргүй баахан юм, хэдэн олон тэрбумаар оруулж ирчхээд та нар баталсан шүү дээ гээд суугаад байх юм биш үү. Энэ тоогоо тавьж орж ирдэггүй байсан юм уу? Тэгээд энэ өмнө нь “нөөцийн мах”

гээд л хийдэг шүү дээ. Хуультай. Хуульгүй, нөөцийн мах гээд л хийж л байсан. Ийм зүйлүүд алга байна.

Тэгээд Улсын Их Хурал энэ ажлаа хиймээр байна. Бүх эрхээ Засгийн газар.../минут дуусав/

Г.Занданшатар: Байнгын хороо хариулна. Ажлын хэсгийн дарга Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: 2012-2015 оны хооронд явсан үнэ тогтворжуулах хөтөлбөрөөс зүгээр хэдхэн том ялгаатай юм.

Нэгдүгээрт, тухайн үед Монголбанк өөрсдөө мөнгө хэвлээд энэ хөтөлбөрийг явуулсан. Үүний үр дүнд монгол төгрөгийн ханш суларсан. 2012-2015 онд. Тухайн үедээ энэ богино хугацаанд зарим нэг бараа, бүтээгдэхүүний үнийг барьж байгаа юм шиг байдалтай байсан боловч дараа нь бусад нь бүх юмны үнэ нэмэгдэж түүнийг бүх ард түмэн амссан. Манай эдийн засагчид бүгдээрээ үүнийг бүгдээрээ сайн мэдэж байгаа байх.

Хоёрдугаарт, үүнийг хэрэгжүүлэхэд Монголбанк. Бид үүнийг бүр хууль болгож ингэж оруулж байгаа юм. Сайн засах зүйлүүд ч гэсэн ажлын хэсэг дээр байсан. Тодруулах зүйлүүд ч гэсэн байгаа.

Тэгэхээр үүнийг өмнө нь Монголбанк бараг Засгийн газраас нэг үүрэг чиглэл аваад хэрэгжүүлчихсэн байдлаар биш иргэд олон нийтийн дунд хэлэлцүүлээд Улсын Их Хурлаар хэлэлцүүлээд хууль болгоод, Засгийн газар нь юугаа хариуцах юм, Монголбанк нь юугаа хариуцах юм гэдгийг ингэж оруулж өгч байгаа нь үнэ тогтворжуулах хөтөлбөрөөс онцлогтой юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, яах вэ, бизнес эрхлэгчдийг дэмжих гэдэг дээр энэ хуулийн зорилго нь арай өөр юм л даа. Энэ хуулийн зорилго гээд үүн дээр бичсэн байгаа. Нэгдүгээрт. Энэ хуулийн зорилго нь олон улсын хямралт байдлын улмаас үүсэж байгаа гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдлоос сэргийлэх. Сөрөг нөлөөлөл гэдэг нь үүнтэй уялдаад Монголчуудын гол нэрийн бараа, бүтээгдэхүүн болоод байгаа мах, гурил, бензин, шатахууны үнэ бусад бараа, бүтээгдэхүүний үнэд нөлөөлөөд байгаа, иргэдийн амьжиргаанд нөлөөлөөд байгаа энэ сөрөг нөлөөллийг, бас бизнес эрхлэлтэд ч гэсэн нөлөөлж байгаа. Энэ нөлөөллийг л бууруулах асуудлыг энэ онцгой журмаар энэ онцгой хуулиар зохицуулж байгаа юм.

Тэгээд энэ хуулийн хэрэгжилт зөвхөн энэ жилдээ хэрэгжээд дуусна. Зарим асуудлууд нь манай ажлын хэсэг дээр, Байнгын хороон дээр ч гэсэн дээ. Иргэдээс сая “**D-Parliament**” дээр ирсэн саналаар ч гэсэн ингэж урт хугацаанд явж болохгүй шүү. Сууриар нь сайжруулах зүйлүүд зөндөө байна шүү гэдэг үнэн.

Бизнес эрх эрхлэлтийг дэмжихдээ 10 их наядын хөтөлбөрийн хэрэгжилтийг Эдийн засгийн байнгын хороон дээр Монголбанк, Засгийн газраас танилцуулга хийсэн. Сая энэ хуулийг хэлэлцэж байх явцад ч гэсэн Хүнс, хөдөө аж ахуйн сайд жишээлбэл, 200 тэрбумаар малчдад мах бэлтгэл гээд ингээд энэ бүгд дээр нь бид дэмжлэг зээл олгож байгаа. Энэ хаврын тариалан эрхлэлтэд 100 тэрбум төгрөг 3.0 хувийн хүүтэйгээр олгож байгаа. 50 орчим тэрбум төгрөгийг ногоо тарьж байгаа иргэдэд дэмжлэг олгож олгож байгаа гээд бизнес эрхлэгч рүү дэмжсэн зээлийнхээ талаар Засгийн газраас Эдийн засгийн байнгын хороон дээр мэдээлэл хийсэн байгаа. Түүнийг Засгийн газар, Монголбанкнаас бүх гишүүдэд шинэчлээд хүргэж болох байх.

Г.Занданшатар: С.Одонтуяа гишүүн 1 минут тодруулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр 2015, 2016 онд Ардчилсан нам яг энэ “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлээд инфляцыг 1.6-д анх удаа оруулж байсан юм шүү. Та нар Сангийн яаманд ажиллаж байсан. Тэр тоогоо нягтлаарай. 1.6-д анх удаа инфляцыг оруулж байсан.

Эргэн төлөлт нь 98 хувьтай байсан. Аж ахуйн нэгжүүдэд зээл өгөхдөө арилжааны банкаар дамжуулж зээл авч байгаа аж ахуйн нэгж өөрөө хариуцлагаа үүрч байсан. Тухайн банктайгаа өөрөө баталгаагаа тохирч байсан.

Миний айгаад байгаа тэр шүү дээ. Одоо Хөгжлийн банк ямар ч барьцаа баталгаагүй баахан зээл шууд өгчихсөн л байгаа шүү дээ.

Тэгэхээр би Монголбанкны Ерөнхийлөгчөөс нэг юм асуумаар байна. Өчигдөр Төсвийн байнгын хорооны дарга шууд та нар мөнгө хэвлэх гэж байна. Энэ арга чинь буруу гэдгийг Төсвийн байнгын хорооны дарга буюу өмнө нь олон жил Сангийн сайд хийж байсан хүн өөрөө өчигдөр Байнгын хорооны хурал дээр хэлсэн. Та нар мөнгө хэвлэх гээд байна шүү дээ. Өөр арга байхгүй шүү дээ, энэ төсөв дээр чинь гээд тэгсэн. Тэгэхээр үүнийг би таны амнаас хариуцлагатай.../минут дуусав/

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, ажлын хэсгийн ахлагч.

Х.Булгантуяа: Үнэн. Инфляц тухайн үед 1.6 хүнд хүрсэн.

Тэгэхдээ энэ бол үнэийг хэлэхэд эрэлт ч байхгүй, эдийн засаг аягүй хүндэрсэн байсны нэг илрэл байсан. 2016 оны гуравдугаар улиралд нөгөө талаараа инфляц 1.6-д хувьд хүрсэн байсан ч гэсэн эдийн засгийн өсөлт хасах 1.3 байна уу, 1.4 байна уу хувьд хүрсэн байсан. Өөрөөр хэлбэл Монгол Улсын эдийн засаг тийм болтлоо агшаад эрэлт байхгүй байсан учраас инфляц тухайн үед тийм түүхэндээ байгаагүй нам доор байгаа.

Гэхдээ тухайн үед “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” явж байхад Монгол Улс цар тахалтай, дэлхий даяар цар тахалтайгаа 4 дэх жилтэйгээ залгаагүй байсан. Тухайн үед дэлхийг хамарсан ийм том дайн болоогүй байсан. Тухайн үед бензин, шатахууны үнэ маш өндөр болж байсан байсан нь үнэн. Үүнийг барих гэж ерөнхийдөө хэрэгжүүлээд л дараа нь бүх барааны үнэ өндөр болоод л үүний ард гарсан.

Үүний хүүгийн зөрүүг хаанаас төлөх гээд байгаа юм бэ гээд. Энэ хууль дээр бичсэн байгаа л даа. Үүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр мах, гурил бэлтгэгч нарт олгоно.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн гүйцээгээд хариулчихъя. Нэмэлт 1 минут. Хариулт 5 минут байж болно гэж байгаа.

Х.Булгантуяа: Хуулийн 6.1.2 дээр энэ хөнгөлөлттэй зээл олгогдох шаардах хүүгийн дотацийг одоо төсвийн тодотгол орж ирнэ. Үүн дээр тавьж оруулж ирэх юм.

Тэгэхээр ерөнхийдөө нийт дүн нь, дээрээс нь нэмээд хөнгөлөлттэй зээлийн, ялангуяа мах, гурилтай холбоотой хөнгөлөлттэй зээлтэй холбоотой хүүгийн дотаци нь орж ирнэ.

Түрүүн Монголбанк мөнгө хэвлэх гээд байгаа юм уу гээд. Энэ яах вэ, бид найруулга дээр нь тэгж уншигдахаар биччихсэн байна гээд. Бид үүнийг зассан. Ажлын хэсгээс. Эдийн засгийн байнгын хороон дээр дэмжигдсэн.

“Банкаар дамжуулан олгох” биш, “банкны эх үүсвэрээр олгох” гэж оруулсан байгаа. Тэгээд яг ипотекийн зээл явж байгаа, 10 их наядын хөтөлбөр явж байгаатай яг адилхан зарчмаар хөнгөлөлттэй зээлийнх нь хөнгөлөлтийнх нь зөрүүг нь төсөв дээр тавиад Засгийн газар удахгүй төсвийн тодотголыг оруулж ирээд Улсын Их Хурлаар батлуулах юм билээ. Тийм.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Нөхцөл байдал амаргүй байгаа.

Тэгээд одоо юу гэдэг юм, гайгүй байна, болж байна, бүтэж байна гэж худлаа хэлээд ард түмнийхээ өмнө хүлээлт үүсгээд улам бухимдуулах шаардлагагүй. Нөхцөл байдлаа хүлээн зөвшөөрөөд, нөхцөл байдлаа яаж даван туулах вэ, яаж ард нь гарах вэ, яаж хохирол багатайгаар монголчууд маань, Монгол Улс маань эндээс гарах вэ гэдэг дээр л бодох ёстой. Юу гэдэг юм, олонх нь цөөнхөө даапаалаад, цөөнх нь олонхоо шүүмжлээд, Засгийн газар нь Их Хурал руугаа чихээд, Их Хурал нь засаг руугаа чихээд үүний ард бид гаргахгүй. Хэн нэгнийг шүүмжлээд, хоорондоо хагарч хуваагдаад,

талцаад үүний ард гарахгүй. Монгол Улс бүгдээрээ л нэг зорилготой, нэг завин дээр сууж байгаа, нэг л зовлонтой, нэг л жаргалтай.

Тийм болохоор үнэхээр хэцүү байгаа. Тийм. Урьд өмнө тохиолдож байгаагүй. Үндсэндээ Дэлхийн 2 дугаар дайнаас хойш дэлхий нийтэд ийм эдийн засгийн хямрал, хүндрэл бий болж байгаагүй гэж ярьж байгаа шүү дээ.

Америкийн Нэгдсэн Улс түүхэндээ байхгүй өндөр инфляцтай болчихсон. Хятад Улсын нөхцөл байдал ямар байна. Одоо Шанхай, хойд бүс нутгаараа. Европын Холбоонд 1 литр бензин 9 мянган төгрөг хүрчихсэн. Германд 1 тийш ширхэг талх 8 мянган төгрөг хүрчихсэн. Оросын Холбооны Улсад олон улсын хоригт орчихсон.

Ийм нөхцөл байдал урьд өмнө Монгол Улсад тохиолдож байгаагүй байх. Монгол Улс хоёрхон хөрштэй. Тэгээд хоёр айл маань хаалгаа хаачихлаа. Нэг нь дотооддоо бид асуудалтай. Энэ КОВИД-оо дарж авна гээд хаалгаа хаачаад бидэнтэй харилцаа үүсдэггүй, худалдаа арилжаа хийдэггүй, экспорт гардаггүй. Нүүрс гол орлого. Түүнээс болж валютын хомстолд орж байна. Тээвэр, ачаа бараа орж ирдэггүй.

Оросын Холбооны Улс гээд хойд хөрш маань дайнаас болоод олон улсын хоригт орчихсон.

Тэгээд үндсэндээ хоёрхон хөрштэй. Хоёр хөршийн дунд ганцхан Монгол Улс байдаг. Ганц Монгол Улс нь энэ хоёр хөршийн хоригийн хоригт орчхоод, үүнээсээ болоод энэ хямралыг давах гэж, үнийн өсөлтийг давах гэж бид бүхий л арга чаргаа хэрэглэж байгаа. Арга чаргаа хэрэглэж байгаа.

Тийм болохоор энэ нөхцөл байдлыг л хэрхэн зөв, богино хугацаанд бага эрсдэлтэй давах вэ гэдэг дээр анхаармаар байгаа юм. Өнгөрснөө яриад, өнгөрснөө шүүмжлээд байх биш. Өнөөдрийнхөө нөхцөл байдлыг бодитойгоор үнэлээд. Үүнийг хэрхэн яаж хохирол багатай гарах вэ гэдэг гарц шийдлээ яриад, яаж бага хохиролтой, бага эрсдэлтэй байх вэ гэдэг дээр анхаарах ёстой. Энэ ч үүднээсээ Засгийн газар “Гол нэрийн” гээд гурил, мах, шатахууны үнийн өсөлтийг тогтворжуулъя. Хангамжийг тасалдуулахгүй байя гэдэг асуудлыг оруулж ирж байна.

Тэгэхээр энэ дээр бид цаашдаа бусад бараа, бүтээгдэхүүн дээр. Энэ чинь дэлхийн зах зээл дээрх бараа, бүтээгдэхүүний өсөлт, хомсдол. Дээрээс нь Монгол Улс валютын ханшийн өсөлт, төгрөгийн ханшийн сулрал. Дээр нь тээвэр, ложистикийн гацаа. Энэ бүхэн чинь үндсэндээ ингээд даблдаад, триплдээд. Одоо юу гэдэг юм давхар давхар цохилт, давхар давхар л хүндрэлийг бий болгох гээд байгаа юм л даа. Тэгээд үүнээс л бид сэргийлэх ёстой юм.

Тэгээд энэ дээр Байнгын хороон дээр ярьсан уу? Энэ асуудлаа хэрхэн яаж шийдэх юм бэ? Бид сахарны асуудал яримаар байна. Будааны асуудал яримаар байна. Эм хангамж, эм, эмийн бүтээгдэхүүний асуудал яримаар байна. Эмийн асуудал.

Эдгээр дээр хэрхэн яаж анхаарах юм бэ? Зөвхөн одоо юу гэдэг юм, бага хүүтэй зээлээр энэ асуудлыг шийдэхгүй. Нөөц бүрдүүлэх. Хангалттай хэмжээний нөөцийг бид бүрдүүлмээр байна. Гурил, будаа, мах, шатахуун, элсэн сахар юу байдаг юм. Энэ зайлшгүй хэрэгцээ бараа, бүтээгдэхүүний нөөцийг. Стратегийн ач холбогдол бүхий бараа, бүтээгдэхүүн нөөцийг бүрдүүлмээр байна. Эмийн бас.

Энэ нөөц бүрдүүлэх тал дээр яаж анхаарах юм?

Мөн яг энэ чиглэлд худалдаа, бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжийнхээ татварыг хөнгөлөх, чөлөөлөх ийм бодлогын асуудлууд яригдсан уу? Өөрөөр хэлэх юм бол энэ гурил, будаа, мах, газар тариалангийн болон гурилын үйлдвэрүүд. Дээрээс нь бензин, шатахуун импортолж байгаа компаниуд. Мөн эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, импортолдог компаниуд дээр нэмэгдсэн өртгийн болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлтүүд эдлүүлж энэ асуудлын гарц шийдэл байх бололцоотой. Энэ тал дээр яригдсан юм болов уу? Энэ талаар асууя.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа ажлын хэсгийн ахлагч асуултад хариулъя.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг дээр энэ талаар яригдсан. Эдийн засгийн байнгын хороон дээр ч гэсэн гишүүдээс бас ярьж байсан.

Өнгөрсөн удаа хэлэлцэх эсэхийг шийдвэрлэсэн. Улсын Их Хурлын чуулган дээрээс энэ асуудлыг Ерөнхий сайдаас ч гэсэн асууж байсан.

Одоо үйлчилж байгаа. Нэгдүгээрт, КОВИД-ын тухай хуулиар эм, эмнэлгийн хэрэгсэл гээд гол бараа, бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх. Үүнтэй холбоотойгоор мөнгөний бодлого дээр ч гэсэн бид 2022 оны мөнгөний бодлогыг батлахдаа бид Монголбанк, Засгийн газарт нэлээдгүй үүрэг чиглэлийг өгсөн байгаа. Одоо ингээд үргэлжлүүлээд явж байгаа. Жишээлбэл, бензин, шатахууны нөөцийг бүрдүүлэхэд репо хэлэлцээ хийгдэх гэх мэтчилэн энэ юунууд явж байгаа.

3.Мэндсайхан сайд энэ ажлын хэсэг дээр, Эдийн засгийн байнгын хороон дээр ч гэсэн нөөц бүрдүүлэх дээр энэ хаврын тариалалт, энэ бүгд дээр бид нөгөө 10 их наядын хөтөлбөрөөр хөнгөлөлттэй зээлүүдийг мал аж ахуй, хүнс хөдөө аж ахуйн салбаруудад гаргаж байгаа. 3.0 хувийн хүүтэйгээр гаргаж байгаа.

Одоо харин бидний батлах гэж байгаа хууль бол намар бараа, бүтээгдэхүүнийг нь шууд хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах мөнгийг нь гурилын үйлдвэрүүдэд, мах нөөцлөгч компаниудад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлдүүлэх эх үүсвэрийг нь бүрдүүлж байгаа юм.

Ингэснээр манай тариаланчид сэтгэл амар энэ хаврынхаа тариалалтыг хийх боломжтой. Худалдан авах эх үүсвэрийг нь ингэж шийдэж өгч байна.

Өмнө нь үүнийг Та бүхэн бараг санаж байгаа байх. Махны нөөцийг бүрдүүлэхэд төсөв дээр голчлон санхүүжилтийг нь тавиад үүнийг нь Хөгжлийн банкаар дамжуулаад мах бэлтгэгч зарим компаниудад олгодог байсан.

Бусад бараа, бүтээгдэхүүнүүдийн хувьд Засгийн газраас. Бид мэдээж бусад бараа, бүтээгдэхүүнүүдийг аль болохоор янз янзын боломж санхүүгээр 3.0 хувийн хүүтэй зээлээс авхуулаад бид дэмжинэ.

Гэхдээ энэ хуулийн туйлын зорилго бол инфляцид нэн түрүүнд нөлөөлж байгаа газрын тос, дээрээс нь нэмээд гол хоёр нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн дээр ер нь тулгуурлая гэж ингэж оруулж ирсэн.

Тэгээд энэ хүрээнд гол тооцооллуудаа хийгээд оруулаад ирсэн юм билээ.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн тодруулна. Дараа нь санал хураалттай. Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалтад явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

С.Бямбацогт: Тэгэхээр 5.1.1 дээр мах, гурилын нөөц бүрдүүлэх, нийлүүлэлтийг тогтвортой байдал хангах зорилгоор мах бэлтгэн нийлүүлэгч, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгө шаардагдах хөнгөлөлттэй зээл олгоно гэж байгаа юм.

Тэгээд хөнгөлөлттэй зээл олгохоос гадна нөөцийг нь хэрхэн яаж хангалттай бүрдүүлэх вэ? Одоо байгаа тэр нөөцүүдийг нь төр худалдаж аваад цаад талд нь эргэлтийн хөрөнгийг нь суллаж өгөөд ингэх юм тэр хэмжээгээр дахин татан авалт, дахин худалдан авалтууд хийгдээд энэ хэмжээгээр үндсэндээ Монгол Улсад орж ирэх. Нэг хэсэг нь төрдөө, нэг хэсэг нь хувийн хчлэн оруулж ирээд энэ нөөц маань үндсэндээ хоёр дахин нэмэгдэх бололцоо байгаа юм л даа. Энэ тал дээр бид анхаарах ёстой.

Монгол Улс хэрэглэгч улс. 100 долларын 70 хувиа импортоор авдаг. Тийм үү. Тэгээд 100 долларын бараа, бүтээгдэхүүн дэлхийн зах зээл дээр 150 болоод нэмэгдчихсэн. 150 доллар нь өнөөдөр 2800 байсан бол 3300 болоод үнэ нь өсчихсөн. Дээрээс нь тээвэр, ложистикийн гацаа, тээврийн зардал нь хэд дахин нэмэгдчихсэн.

Энэ өсөлтүүд чинь ингээд яалт ч үгүй юу гэдэг юм, урьд нь байж байсан бараа, бүтээгдэхүүнийг 50 хувиар.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулт хангалтгүй бол асууна. Дараа нь санал хураалттай шүү. Х.Булгантуяа гишүүн хариулъя.

Х.Булгантуяа: Төсвийн тодотголтой холбоотойгоор зарим бусад бараа, бүтээгдэхүүн, тариалалтыг татвараар дэмжих асуудлууд яригдаж орж ирэх юм билээ.

Гишүүдээс ч гэсэн энэ саналыг манай ажлын хэсгийн гишүүн, Ч.Ундрам гишүүн жишээлбэл бас энэ асуудлуудыг хөндөж гаргаж ирж тавьж байсан. Энэ хавар нөөц бүрдүүлэх дээр, импортолж оруулж ирэх дээр гэх мэтчилэн.

Тэгэхээр үүнийг төсвийг дагуулаад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлуудыг оруулж ирж шийдэх нь зүйтэй гэж үзсэн юм.

Энэ хуулийн гол зорилго бол энэ гурван бараа, бүтээгдэхүүн дээр байгаа учраас. Тэгээд үүнийг ерөнхийдөө бэлтгэн нийлүүлэхтэй холбоотой байгаа учраас одоогоор энэ гурвын зүгээр дотоодын үйлдвэрлэлийг дэмжье. Тэгээд дээрээс нь нэмээд нөөц бүрдүүлэх дээр нь ажиллая гэсэн. Яагаад гэвэл мах, гурил хоёр бол гаднаас импортолж оруулж ирэхгүй шүү дээ. Мах, гурил хоёрын хувьд дотооддоо үйлдвэрлэнэ. Дотоодын харин ханган нийлүүлэгчдийг л дэмжье. Нөөц хангалттай бүрдэхэд нь.../минут дуусав/

Г.Занданшатар: С.Бямбацогт гишүүн. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Тэгэхээр үндсэндээ валютын ханшын өсөлт, дээрээс нь тээвэр, ложистикийн гацаа саатлаас болсон үнийн өсөлт, дээрээс нь дэлхийн зах зээл дээр бидний хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт гээд энэ юмнууд чинь давхар давхар бараа, бүтээгдэхүүнээ өсгөх гээд байгаа юм л даа.

Тийм болохоор л энэ дээр юу гэдэг юм, нөөцөө эртхэн шиг, тийм үү, бага дээр нь, бага өсөлттэй байгаа дээр нь бүрдүүлж авах юм сан. Зөвхөн гурил, мах гэдгээсээ гадна тэр элсэн сахар, будаа, эм, эмнэлгийн хэрэгсэл гэдэг юмнууд дээр анхаарах ёстой шүү. Үүнийг Та бүхэн хуулиа хэрэгжүүлэх явцдаа давхар анхаарч явах ёстой. Улсын стратегийн нөөцийн бүтээгдэхүүнийхээ хуульд энэ бүтээгдэхүүнүүд орчихсон байдаг.

Тийм болохоор зөвхөн энэ хуулиар батлагдсан гурил, мах, шатахуун гэдгээс гадна бусад стратегийн бүтээгдэхүүнд анхаарах ёстой шүү гэдгийг л хэлье дээ. Нөөцөө сайн бүрдүүлэх тал дээр. Үнийг өсөхгүй, хангамжийг тасалдуулахгүй байх тал дээр.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 11 санал байгаа. Бүртгэлийн санал хураалт явуулна.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн.

Төслийн гарчгийн “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэснийг хасах. Энэ саналтай холбогдуулан төслийн 1.1 дэх хэсэгт заасан хуулийн зорилгод байгаагаас бусад төслийн зүйл, хэсэг, заалтад байгаа “олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа, Жамбалын Ганбаатар, Тогмидын Доржханд, Бөхчулууны Пүрэвдорж, Чинбатын Ундрэм, Чимэдийн Хүрэлбаатар, Содномын Чинзориг, Баттогтохын Чойжилсүрэн. Цаашид “Ажлын хэсэг” гэнэ.

Асуулт зарчмын зөрүүтэй саналын томьёолол дээр байхгүй. Дэмжсэн, дэмжээгүй үг л хэлж болно.

Үүнээс хойш Ардчилсан намын бүлгийн саналыг бүх гишүүдийн гарын үсэг зурсан саналаар л тооцно шүү. Одоо ер нь учир нь олдохоо байлаа ерөөсөө. Завсарлага цаашдаа тийм л зарчмаар явна.

Дашдондогийн Ганбат гишүүн дэмжээгүй үг хэлнэ. Цэвэгдоржийн Туваан гишүүн дэмжсэн үг хэлнэ. Тасаллаа.

Д.Ганбат: Хэдэн минут байдаг юм. Энэ юу вэ. Энэ Олон улсын хямралт нөхцөл байдал гэнэ үү. Энэ улс гэдэг нь хэдэн улс байдаг юм бол оо? Дэлхий дээр 200 улс л байдаг байх. Тэрний хэд нь олон улс гэдэг нэр томьёон дотор орчхоод байгаа юм. Хэдэн улс нь хямарчихаад байгаа юм. Хямралтай нөхцөл байдалтай холбогдоод гэж яриад байгаа. Үүнийгээ товчлоод “дайнаас” гээд явчихвал яасан юм. “Тусгай ажиллагаа” гэдэг байснаа одоо “дайн” болсон байна.

Иймэрхүү нэртэй хууль батлаад дараа нь онигоо болно шүү нөхдүүд ээ. Нөгөө 76 ямаа гэдэг шиг бас нэг тиймэрхүү нэр устай болох байх.

Олон улсын хямралт нөхцөл байдал. Үндсэндээ тэр гурил, мах хоёр манай улсад байж л байгаа зүйл шүү дээ. Энэ чинь гөлөг тойруулж байгаад л үйл ажиллагаа шүү дээ. Манай нэг Ерөнхийлөгч байсан нөхөр их сайн хийдэг байсан юм. Та нар их сайн суралцаж л дээ. Эхлээд хамт төрүүлдэг байсан. Одоо өөрсдөө төрүүлдэг болж. Монголын ард түмнийг гөлөг төрүүлж байгаа юм шиг иймэрхүү юм хийдэгээ боль оо, та нар.

Үндсэндээ валют л байхгүй байгаа шүү дээ. Тэр валютын урсгалыг тасдуулсан. Үүнтэй холбоотой шүү дээ. Цаана нь өчнөөн бараа байна шүү дээ. Тэр будаа энэ тэр гээд л. Тийм ээ.

Монголын ард түмний хэрэглээ сайжирсан шүү. Энэ ардчиллын 30 жилд. Тэр Атрын хэддүгээр аян билээ. Баахан аян зохиосон. Баахан мөнгө төгрөг үрсэн. Одоо тэнгэр хангай гайгүй байвал 70 сая малтай болчихсон. Авдаг юмаа авдгаараа л авчихна шүү дээ. Тэрийг нь хэн нэгэнд нь. Бас баахан хүн шоронд явж таарах байх шүү. Дараа нь. Тэгээд яах юм. Олон улсын нөхцөл байдлаас болж шоронд явсан гэх юм уу. Аан. Нэг тиймэрхүү л юм болно доо.

Би нэг Ванга шиг хэлье гээд хэлдэг байсан юм. Би тэрийг гаргасан юм. Ц.Нямдорж гишүүн дандаа л урьдчилж хэлээд байдаг юм. Би хэлчихье. Ванга шиг.

Энэ чинь ямар ч үр дүн байхгүй. Бөөн онигоо. Энд юу гэлээ. Тэр Х.Булгантуяа гишүүн. Тэр төсвөөс зөрүүг нь төлчихдөг юм гэж байна лээ.

Тэр Н.Алтанхуягийн Засгийн газар бол буруу юм хийсэн шүү дээ. Дараа нь тэр ханшны зөрүүгээр ёстой будаа болсон шүү дээ. 1700 байсан гээд л Ж.Мөнхбат гишүүн сэгсрээд л байсан. 2100 болчихсон байхгүй юу.

Одоо тэгээд л ахиад л явж өгнө. Энэ чинь. Тэндээс хэдхэн хүн хождог байхгүй юу. Тэр ямар хамаатай юм.

Ер нь буруу зүйл хийж байна. Энэ чинь зах зээлийн эдийн засаг. Бид 30 жил болчихсон байна. Та нар ийм чадахгүй юм уу. Чадахгүй бол больчихгүй юу даа. Ажлаа хий гээд байна шүү дээ. Ажлаа хийж чадахгүй больчих. Монгол Улсын Үндсэн хуульд заачихсан байгаа. Монгол Улсын хууль дүрэмд заачихсан байгаа. Хэнийг ч албадаж хөдөлмөр эрхлүүлэхгүй. Хэнийг ч албадаад байгаа юм байхгүй.

Монголын ард түмний төлөө зүтгэнэ гээд тангараг өргөсөн юм бол олигтойхон зүтгэ. Эдийн засгаа мэддэггүй юм бол унш. Зах зээлийн эдийн засгийн хамгийн наад талын юм мэдэхгүй байна шүү дээ. Та нар.

Бараа, таваар алга болдог юм, байхгүй болдог юм, хар зах бий болдог юм. Социализм юм уу. Хаашаа юм энэ чинь. Ийм хариугүй амьтад байж ийм

юм яриад сууж байх. Одоо энэ хувийн сургуулийн эдийн засгийн нэгдүгээр курсийн оюутнууд шоолно шүү. Бид нарыг. Ийм юм яриад сууж байгааг.

Энэ чинь татвар төлөгчдийн нуруун дээр л үүрдэг байхгүй юу. Тэр Х.Булгантуяа гишүүн гуай хямдхан мах идэж яадаг юм. Тийм. Одоо энэ Б.Дэлгэрсайхан бол хэд л бол хэдээр мах идэж болно шүү дээ. Тийм. Тэгээд яах юм. Тэр гурав, дөрвөн хүүхэдтэй адилхан. Тийм ээ. Тэр 30 хувь нь ядуурчихсан хүнтэй адилхан мах иднэ гээд сууж байх юм уу. Тэгээд нэлээн хэдэн хүнийг шоронд явуулах нь л дээ.

Энэ олон улсын хямрал гэдэг юмаа боль оо, та нар. Одоо тэгээд Ардчилсан нам буруутай, ард түмэн буруутай гэдэг байсан бол одоо олон улс буруутай болох нь л дээ. Тэр ямар улс нь буруутай юм. Энэ дээр бич л дээ. Та нар. Тийм.

Одоо хар л даа. Та нарын тэр гадна дотно өргөж байгаа санал, энэ тэр юмыг нь хар. Тэр 200 мянган доллар хандивласан байна лээ. Энэ чинь хүн төрөлхтний хамгийн наад захын жишиг шүү дээ.

Одоо олон улс ч байхгүй, Оросын Холбооны Улс ч байхгүй болж байна шүү дээ. Та нар ийм хариугүй байхгүй юу даа.

Одоо та нарын хэн ч албадаад байгаа юм байхгүй. Улсын Их Хурал гэж одоо байхгүй боллоо шүү дээ. Яршиг зүгээр. Тэр Засгийн газар нь 18 яамтай болоод 18 сайдтай болчихсон юм байна лээ. Бүр нэгтгээд нэг болгочихсон нь дээр. Баахан машин хэмнэж байгаа юм гэнэ лээ. Тэр нь өрөвдөлтэй дөө. Больж үз. Та нар ажиллаж чадаагүйн үр дүн байхгүй юу.

Төмөр замаа олон улсын стандартын дагуу тавьчихсан бол яах юм. Өнөөдөр хамгийн супер циклийн үе шүү дээ. Хамгийн боломжтой үе шүү дээ. Ийм сайхан үед засаг төр барьж байж, ийм олуулаа байж Монголын ард түмнийг ингэж амьдруулж байгаа нь ичгэвтэр шүү дээ.

Зах зээлийн эдийн засгийг зах зээлийн эдийн засгаар нь явуул л даа. Үүний төлөө 30 жил явж байна. Ингээд л баахан уянгалаад л. Тийм ээ. Юмны үнийг нь буулгаж өгнө гэхээр хүн болгон дуртай байдаг юм. Амьдрал дээр энэ чинь хэрэгждэггүй юм. Бүх системээ нураагаад дуусдаг юм.

Тэгээд Монголбанк ч гэсэн тусдаа байх хуультай.../минут дуусав/

Г.Занданшатар: Д.Ганбат гишүүн ээ. Наад хуулиа унш. Энэ “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэдгийг чинь хасах саналаар санал хураах гэж байна. Та тэгсэн чинь тэрийг дэмжихгүй гээд. Тэр хасах саналыг нь хасахыг нь хасахын эсрэг санал хэлээд байх юм. Одоо үүнийг чинь яаж ойлгох юм.

Наад төмөр зам энэ тэрийг чинь та нар л батлаа биз дээ.

Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ зарчмын зөрүүтэй санал дээр дэмжсэн, дэмжээгүй үг хэлж байгаа учраас энэ “олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэдгийг хасах саналыг дэмжиж байна. Тийм. Энэ хуулийн нэр томьёо дээр үүнийг хасах нь дээр байх.

Тэгээд энэ нэг үг байгаа. Үүнийг дахиад хэлчихье. “Дайнаа ирэхээр дариа нь нухна” гээд. Энэ бол хоцорч байгаа арга хэмжээ шүү. Аль эрт авах байсан юм.

Яагаад үүнийг эрт аваагүй гэхээр өмнө нь Ардчилсан намын Засгийн газрыг яг үүгээр нь мялаж мялаж, та нар буруу зүйл хийсэн гэж баахан улс төр хийчихсэн. Түүндээ нэлээн гацаад удчих шиг боллоо.

Энэ чинь орж ирэхээс өөр арга байдаггүй юм. Инфляцыг барихын тулд ерөөсөө нэг, хоёр, гурав, дөрөв гээд явдаг бүтээгдэхүүн дотор чинь наад энэ мах, гурил, бензин гээд ороод ирдэг байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь бид тэр үед бас яг энэ дагуу л хийсэн арга хэмжээ орж ирж байгаа учраас үүнийг хуулийг нь ерөнхийд нь дэмжиж байгаа юм. Жоохон цаг хугацааны хувьд оройтсон болохоос биш.

Тэгээд сая тэр асуудал дээр ажлын хэсэг ахалж ажилласан Х.Булгантуяа гишүүний үг дээр би гайхаж байна. Юу гэхээр эхний гурван бүтээгдэхүүн байгаа. Бензинийг бол ёстой яалт ч үгүй яг зөв. Яагаад гэхээр бензиний үнийг 1000-гаар алдчихвал бид бүх юмныхаа үнийг алдана.

Тийм учраас бид эндээс мөнгө гаргаад тэр шатахууны компаниуд урьдчилсан захиалгаа өгөөд, одоо тэр төлөвлөгөөнд нь мөнгө төгрөгөө төлж оруулаад татаж авах ёстой.

Бензин бид яагаа ч үгүй байгаа үед жоохон хомсдохоор юу болдог билээ дээ. Хэдэн мянгаараа колонк дээр очерлоод асуудал үүсдэг шүү дээ. Тэгэхээр энэ бол зөв.

Хоёрдугаарт, мах, гурилч гэсэн зөв л дөө. Яагаад гэхээр махны үнэ, гурилын үнэ, бензиний үнэ, барилгын материалын үнэ бол инфляцын нэг номерын хүчин зүйлүүд.

Тэгэхээр энэ мах бэлтгэнэ гэдэг дээр би түрүүн Байнгын хороон дээр, энэний түрүүний чуулган дээр хэлсэн. Үүнийг ажлын хэсгийн даргаас энэ дээр асуучихъя.

Тэгээд дараагийн мэдээж Байнгын хороогоор орох байх. Юу вэ гэхээр, Монголын бүх мал турчихсан? Одоо энд яаралтай горимоор баталж байгаа энэ хуулиар мах худалдаж авна гээд махны компаниудад мөнгө өгнө гэж батлаад байгаа чинь л сонсогдохгүй байна.

Нөөц бүрдүүлнэ гэж угаасаа байхгүй шүү. Тэр худлаа үг шүү.

Дээрээс нь дахиад хэлье. Улаан буудай. Одоо тариалалтын цаг үе. Монголд зарагдаагүй улаан буудай байхгүй. 40-өөд орчим мянган тонн улаан буудайн борлуулалтын асуудал яригдаж байгаа. Одоо тариад намар хурааж аваад дараа нь борлуулалт ярих юман дээр гурилын үйлдвэрүүдийг санхүүжүүлэх мөнгөө гэж тайлбарлаад байгаа чинь бас худлаа. Сонсогдохгүй байна.

Тэгэхээр энэ бол гурилын үйлдвэрүүдэд энэ мөнгийг чинь авах ч гурилын компани байхгүй шүү. Энэний өнгөрсөн намар бид шахаж байгаад Засгийн газар дээр шийдвэр гаргаад аваад аваад 40 тэрбум төгрөгийн мөнгө авчихсан байгаа. Дахиж авах мөнгө байхгүй. Энэ мөнгө нь Хөдөө аж ахуйн сайд дээр сунгагдаад явж байна лээ.

Одоо тэгэхээр яах юм бэ гээд. Энэ махны үнийг савлуулдаг инфляц үүсгэдэг гол тэр туранхай үед нь мал нийлүүлдэг энэ фермерүүд рүүгээ энэ мөнгөө хий л дээ. Өнөөдөр хаврын тариаланчдын зөвлөгөө хийж байгаа тариаланчдадаа энэ мөнгөө хий л дээ.

Ингэж байж мах үйлдвэрлэгч фермерүүд малчид, тэгээд эрчимжсэн аж ахуй эрхлэгчид, дээрээс нь тариалалт хийх гэж байгаа үр тарианы компаниуд тэр ноднингийн борлуулалт муугаас болоод тарих эсэх нь эргэлзээтэй. Рапс тарина гээд ярьж байгаа. Өнөөдөр Тариаланчдын чуулган дээр нэлээн асуудал болж байгаа. Аж ахуйн нэгжүүд рүүгээ энэ мөнгөө өгчих л дөө. Тэд нар чинь тэр лүүгээ л хийнэ. Тэр лүүгээ л хийгээд тариад гараад ирнэ.

Тэгэхээр иймэрхүү зөрүүтэй бодлогын шийдэх асуудлуудаас болоод энэ оруулж ирж байгаа чухал зүйл чинь шүүмжлэлд өртөөд байна. Унаж магадгүй. Бас ингээд хүмүүс дэмжихгүй. Ингээд янз бүрийн буруу зөрүү ойлголт. Сая тэр нөөц бүрдүүлнэ гээд л эртээд сайд хэлсэн. Та сая хэлсэн. Энэ бол яг ний нуугүй хэлэхэд хаана, хэн авч бүрдүүлэх юм? Банкаар онцгой байдал мөнгө авч нөөц бүрдүүлэх юм уу? Энэ худлаа шүү.

Тэгэхээр үүнийг анхаараад дараагийн хэлэлцүүлэг дээрээ анхаараарай.

Г.Занданшатар: Тийм. Өнөөдөр бид бас Үйлдвэрлэгчдийн холбоотой, Тариаланчдын холбоотой уулзалт хийсэн. Нөөц бүрдүүлэх асуудлыг төсвийн тодотголоор юм уу, Хөдөө аж ахуйн сайд саналаа оруулж ирэхээр тохирсон байгаа.

Ер нь Улсын нөөцийн тухай хуулиар хүнсний буудай, нөөц бүрдүүлж болох юм билээ. Сая 100 мянган тонныг нэмж авах шаардлагатай юм билээ. Тэр яах вэ. Тэр бол экспортод квот өгч гаргаж болно. Тэгж үйлдвэрлэлээ дэмжих хэрэгтэй. Валют олж болно.

Ингээд санал хураалт явуулна. Санал хураалт. Үг хэлж дууссан.

33 гишүүн дэмжиж, 60.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр. Төслийн 5.1 дэх хэсгийн “банктай хамтран” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

33 гишүүн дэмжиж, 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Мөнгө хэвлэх биш. Энэ банктай хамтран гэдэг биш. Нөгөө харин банкаар дамжуулан олгох гэсэн дараагийн санал хураана. Одоо энэ дээр гарна.

Гурав. Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “банкаар дамжуулан олгох” гэснийг “банкны эх үүсвэрээр олгох” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ газар тариалангийн үйлдвэрлэлийн. 400.0 тэрбум билүү? Б.Жавхлан сайд аа. Тэрнээс 200 нь билүү. 40 нь ч билүү. З.Мэндсайхан сайдаас асуучих. Ц.Туваан гишүүн. З.Мэндсайхан сайдаас.

31 гишүүн дэмжиж, 57.4 хувийн саналаар энэ дэмжигдлээ.

Дөрөв. Төслийн 5.1.2 дахь заалтын “хөнгөлөлттэй санхүүжилтийг банкаар дамжуулан” гэснийг “санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

Одоо ингэхээр чинь энэ төсвийн тодотгол хийх зайлшгүй шаардлагатай болж байгаа юм даа. Б.Жавхлан сайд аа. Тэгэхээр хүүгийн зөрүүг нэмэгдүүлэх шаардлагатай болох нь байна шүү дээ. Хүүгийн зөрүүгийн дотацийг.

Тав. Төслийн 5.1.3 дахь заалтыг “санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан энэ хуулийн 3.2.1-т заасан бараа, бүтээгдэхүүний импортод шаардлагатай гадаад валютыг ханшийн эрсдэлийг бууруулж импортлогчид нийлүүлэх

бөгөөд банк энэ эх үүсвэрээр ашиг олох зорилгоор арилжаа хийхийг хориглох;" гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.

Цэдэвийн Сэргэлэн, Хаянгаагийн Болорчулуун гишүүнээр тасаллаа.

Цэдэвийн Сэргэлэн гишүүн үг хэлнэ.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би энэ саналыг дэмжиж байгаа.

Тэгээд энэ микрофон авч үг хэлэх гэсэн юм. Ер нь энэ нөхцөл байдал энэ удаа бид ямар нэгэн арга хэмжээнүүдийг аваад тэгээд дуусах нь ойлгомжтой.

Ер нь цаашдаа яах юм гэдэг дээр бас санаа зовоод байгаа юм. Монгол Улс цаашдаа өнө мөнхөд оршин тогтнож таарна. Тэгээд энэ мэт онцгой нөхцөл байдал үүсэхээр тэгээд л төсөв рүүгээ дайрдаг. Хэд хоноод юм уу, хэдэн сар болоод төсвийн тодотголоо хийдэг ийм байдал руу.

Хоёрдугаарт, нөөцийн асуудал яриад эхэлдэг. Тэгээд энэ байдлаараа бид цаашдаа үргэлж явах юм уу гэдэг дээр би санал хэлье гэж бодож байна.

Ер нь энэ байдлаас гарахын тулд одоо яах ёстой вэ гэвэл бид онцгой нөхцөл байдал үүссэн үеийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгтэй юм шиг санагдаад байгаа юм. Нийгэм, эдийн засгийн бүхий л харилцааг онцгой нөхцөл байдалд зохицуулсан ийм эрх зүйн зохицуулалтыг хийх ёстой. Энэ эрх зүйн зохицуулалт дотроо нөөцийн тухай асуудлыг бүр тусгайлан авч үзээд төсөвт хүрдэггүй. Онцгой нөхцөл байдал үүслээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл юм уу, Засгийн газар хуралдаад нөөцөө хөдөлгөж эхэлдэг.

Тэгээд төсөв явдгаараа явдаг. Тэр нэмэгдэл авах арга, хэмжээнүүдийн зардлуудыг нөөцөөсөө гаргадаг. Стратегийн нөөц гэж хэлж болох байх.

Тэгэхээр нөөцийг ямар үед ашигладаг юм гэвэл хүндэрсэн үед л ашигладаг шүү дээ.

Ер нь одоо байж байгаа нөөцүүд, улсын нөөц байж байна, валютын нөөц гээд байж байна. Тэгээд нүүрс нэмэгдүүлэх тухай бид яриад байгаа юм. Би бол одоо байгаа нөөцөө ашиглах тухай ярина гэж ойлгоод байгаа. Яагаад гэвэл одоо бүрдүүлсэн байгаа нөөцийг чинь бид хүндэрсэн үед л ашиглах гэж бүрдүүлсэн нөөц. Байдал хүндэрчихлээ. Бид тэр нөөцөө гаргая. Үүцээ задалъя. Энэ асуудлыг зохицуулахын тулд нөөцөөсөө хэрэглээд паралельно ахиад нөөц бүрдүүлэх асуудлыг хийгээд явах нь зөв гэж би үзэж байгаа юм. Хүндэрчихсэн хойно, элгээр нь бүр хэвтүүлсэн хойно нөөцөө задлах юм уу, бид.

Тэгэхлээр резерв гэдэг ухагдахуун бол цагийн байдал хүндэрсэн үед яг одоогийнх шиг ийм нөхцөлд задлах ёстой, хэрэглэх ёстой нөөц гэж би ойлгож энэ асуудалд хандаж байгаа юм.

Тийм учраас цаашдаа бид нөөцийг хүрэлцэхгүй хэмжээнд байлгахын тулд заавал улсын стратегийн нөөцийг бүрдүүлдэг тогтвортой эх үүсвэрийг бий болгож хуульчилж өгөөд онц байдлын нөхцөл үүссэн үед үүнийг уг нь онолын хувьд “онцгой нөхцөл байдал” гэж бид ярьдаг л даа. Энэ **“онц байдлаас”** өөр **“онцгой нөхцөл байдал”**.

Тэгээд энэ үед нь хэрэглэдэг энэ нөөцөө бүрдүүлэх асуудлыг л би хэд хэдэн удаа ярьсан юм. Магадгүй гадаадын зах зээл дээр манай Монгол Улсаас экспортод гаргаж байгаа ашигт малтмалын түүхий эдийн үнэ огцом өссөний зөрүүгээр стратегийн нөөцөө бүрдүүлээд явдаг байж ч болох юм. Энэ бол зүгээр би жишээ хэлж байгаа юм. Энэ мэтчилэн бид үндсэндээ хөдөлшгүй нэг сайн нөөцтэй Монгол Улс цаашдаа байх ёстой гэдэг л зарчмын санаа. Тэгээд нөөцийг ашиглая. Эргүүлээд бүрдүүлье.

Алтны худалдан авалтыг нэмэгдүүлэхэд зориулж алт худалдан авалтыг урамшуулъя гэсэн төсөл энэ хууль дээр явж байна. Маш сайн. Дээр нь гадаадаас зайлшгүй бид 100 хувь хараат газрын тосны бүтээгдэхүүнийг худалдан авах нөөц бүрдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлье.

Би энэ хоёр дээр хоёр гараа өргөөд дэмжиж байгаа. Энэ гарцаагүй асуудал. Зүй тогтлын асуудал бөгөөд жам ёсны асуудал. Харин мах, гурил гэдэг асуудал дээр дэмжиж байна. Одоо авахаас өөр арга байхгүй. Гэхдээ яагаад энэ махны үнэ өсөөд байдаг юм гэдгийг нь судалж үзмээр байна.

Монгол Улсын мал өсөөд байдаг. Махны үнэ нь өсөөд байдаг. Дотоодын улаанбуудайн хэрэгцээгээ 100 хувь хангалаа гээд мэдээлэл яваад байдаг. Гурилын үнэ өсөөд байдаг. Энэ ямар шалтгаантай юм. Үнэхээр өсөөд байгаа юм уу. Бодит шалтгааны улмаас өсөж байгаа бол өөр хэрэг. Зохиомлоор гурил, махны үнийг өсгөөд байна уу, үгүй юу гэдгийг Засгийн газар бүр тусгайлан ажлын хэсэг байгуулж ул суурьтай судалж үзэх зайлшгүй шаардлага байна гэж би хэлэх гээд байгаа юм шүү. Үүний үндсэн дээр авах арга хэмжээнүүд цаашдаа явагдах ёстой.

Ер нь онцгой нөхцөл байдлын үед үнэд Засгийн газар оролцдог нь одоо энэ гарцаагүй байдал. Ер нь зах зээлийн жамаараа явах юм бол Засгийн газар үүнд оролцоод байх шаардлага байхгүй. Эдийн засгийн хуулиараа өрсөлдөөнийхөө жамаар явах ёстой л гэж.../минут дуусав/

Г.Занданшатар: Энэ маш чухал санал шүү. Энэ КОВИД-ын хууль, энэ хуулиудыг Гамшгийн тухай хууль гэж байгаа юм. Энэ бол Онц байдлын тухай хууль гэж байдаг юм. Дайны байдлын тухай хууль гэж байдаг юм. Онцгой

нөхцөл байдлын тухай хууль болгоод энэ нэмэлт, өөрчлөлт хийгээд цогцоор нь ийм юм хийх ажлын хэсэг байгуулъя гэж бид ажлын хэсэг байгуулж байсан юм.

Тэгээд тэр дээр Ц.Сэргэлэн гишүүн орж ажиллаарай.

Хоёрдугаарт, нь энэ талаар Улсын нөөцийн тухай хууль дээр бас энэ заалт байдаг юм. Стратегийн нөөц бараа. Улсын Их Хурал баталдаг юм. Эх үүсвэрийг нь одоо шинэчилж өгөх ёстой юм.

Одоо Хаянгаагийн Болорчулуун гишүүн. Дараа нь санал хураалт явуулна.

Х.Болорчулуун: Энэ импортлогчид шаардлагатай байгаа валютыг ханшийн зөрүүнээс хамгаалах 3.2.1-д заасан бараа, бүтээгдэхүүнийг импортлоход гэж байна.

Би сая энэ хооронд асуучихлаа л даа. Зөвхөн нефть дээр гэж байна. Үнэхээр гурил энэ тэр дээр бол хэрэг байхгүй л дээ. Ноднин 200 мянган тонн улаан буудайг Оросын Холбооны Улсаас намар хүртэл импортоор авчихсан. Монгол өөрсдөө 500-гаад мянган тонн улаан буудай хураачихсан.

Ер нь энэ жилийн ургац хүртэл будаа тарианы нөөц хангалттай байгаа. Харин энэ жил улам сайн тариалах бэлтгэл ажил. Энэ дээр л улс анхаарах хэрэгтэй гэж хэлэх байна.

Би сая асуучихлаа. Зөвхөн нефть дээр гэж байна.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

35 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар санал бичигдлээ.

Зургаа. Төслийн 6.1.2 дахь заалтын “жилийн батлагдсан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх замаар шийдвэрлэх” гэснийг “тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэх” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

Яг энэ зарчмын зөрүүтэй саналтайгаа л холбоотой санал хэлнэ шүү. Салдангийн Одонтуяа, Сандагийн Бямбацогт нараар тусаллаа.

Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ зарлага нэмэхгүйгээр гэж орж ирсэн байгаа. Тэгэхээр үүнийг мэдээж зарлага нэмэхгүйгээр л гэж явахаас өөр арга байхгүй.

Тэгэхээр би Сангийн сайдад, одоо энэ чинь бид санал хэлэх болохоор саналаа хэлье. Жишээлэхэд, бид тодотгол хийхдээ бас орлогоо. Б.Жавхлан сайд аа, би танд нэг санал хэлж байна. Орлогоо бид тодотгох болох байх даа. Яагаад гэхээр жишээлэхэд зүгээр бид чинь бараг 4 их наяд ил орлого олно гэхихсэн. Өнөөдөр маш их орлогын юунууд тасарчихсан. Ганцхан нүүрс дээр л би хэлье л дээ. 36 сая тонн нүүрс оруулж ирнэ гэсэн. Тодотголоор 22 болсон уу, яалаа. Гэтэл одоогийн байдлаар чинь 2-хон сая тонн нүүрс гарчхаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид энэ орлого талаа энэ тодотголоор дахиж өөрчлөх юмнууд гарах болов уу л гэж санал хэлэх гээд байна.

Гол нь би энэ хууль дээр юу дутуу байна гээд хэлээд байна гэхээр энэ яаралтай горимоор бид энэ экспортоо эрчимжүүлэх, энэ боомтын гарцаа нэмэгдүүлэх энэ чиглэлийн зүйлүүдийг оруулж ирмээр байна. Энэ асуудлаа ер нь хэзээ оруулж ирэх вэ? Энэ санал шүү.

Ер нь үүнийг нэг ажилламаар байна. Тэгээд сая тэр Ц.Сэргэлэн гишүүн их зөв санал хэлж байна шүү дээ. Улсын Их Хурал бол бид хуулиа батална.

Тэгээд нэг нөхцөл байдал гарангуут л ингээд л дахин дахин хууль оруулж ирээд байх нь буруу байхгүй юу. Жишээлэхэд, бид юу оруулж ирэх ёстой юм бэ гэхээр Засгийн газар хямралт нөхцөл байдлыг даван туулах төлөвлөгөө юм уу, эсвэл хөтөлбөр боловсруулж оруулж ирээд үүнийгээ Улсын Их Хурлаар батлуулах ёстой байхгүй юу. Түүнээс дандаа ингээд бүх юм нь дээр хуулиар самраад байж болохгүй шүү дээ. Самраад байж болохгүй.

Тэгээд сая Г.Занданшатар дарга маш тодорхой, их зөв санал хэллээ. Одоо КОВИД-ын хуулиа өөрчил өө. КОВИД чинь энгийн горимд шилжсэн. Тэр Гамшгийн тухай хуулиар зохицуулъя. Гамшгийн тухай хуулиа нэмэлт оруулах, өөрчлөлт оруулахаа хийж оруулж ир ээ гээд олон удаа хэлээд байгаа шүү дээ. Энэ чуулган дээрээс.

Тэгэхээр энэ асуудлаа шийдэхгүй бол сая Ц.Сэргэлэн гишүүний хэлдгээр нэг юм болохоор л төсвөө самарч байдаг. Нэг юм болохоор л хууль өөрчилж байдаг. Энэ бол буруу шүү. Бид өмнө нь үнэ тогтворжуулах хийж л байсан. Зүгээр Монголбанк Засгийн газартайгаа санамж бичиг байгуулаад банкуудтайгаа гэрээ хэлцэл хийгээд л явдаг.

Одоо тэгээд энэ хууль гээд л оруулж ирж байгаа. Ийм хууль ер нь хараагүй л юм байна.

Тэгэхээр Эдийн засгийн сайдаа томилооч ээ. Хурдхан шиг. Яагаад Эдийн засгийн сайдаар томилохгүй байгаа юм бэ. Ийм эдийн засгийн хүнд байдалд орчхоод Эдийн засгийн сайдаа томилохгүй юм. Сонин. Та нар эсвэл нэг хүн захиалчхаад нөгөө давхар дээл нь зөвшөөрөхөөр болно гээд хүлээгээд байгаа юм уу? Х.Болорчулуун гишүүн тийм гэж байна шүү.

Тэгэхээр хурдан Эдийн засгийн сайдаа тавьчих л даа. Тэгээд дараа нь тэр хүнийг чинь янз янз, өөрчилж болох байлгүй дээ. Одоо эдийн засаг чинь бүр шалбаагт шийдчихлээ шүү. Үүнийгээ тэр орлох талаа анхаарч орж ирээрэй л гэж хэлэх гэсэн юм.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: 6.1.2 дахь заалтыг өөрчилж байгааг дэмжиж байгаа.

6.1.2 дахь заалт дээр юу гэж байсан бэ гэхээр төсөв хооронд, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх замаар эх үүсвэрийг шийдвэрлээ гэсэн заалт байсан.

Энэ бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх. Төсөв батлах, төсвийн гүйцэтгэлийг хянах. Энэ онцгой бүрэн эрх рүү халдсан заалт байсан. Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрх рүү.

Мөн Төсвийн тухай хуулийн төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалтыг хийх болбол тухайн жилийн төсөвт зөвхөн тодотгол хийж шийдвэрлэнэ гэсэн заалттай зөрчилдөж байсан. Мөн шинээр төсөл, арга хэмжээг Төсвийн хуульд тусгагдаагүй шинээр төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно гэсэн заалттай зөрчилдөж байсан.

Тийм болохоор үүнийг өөрчлөөд тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэх гэж орж ирж байгаа юм байна.

Тэгэхээр үндсэндээ тухайн жилийн төсөвт тусгана гэдгийг маань тусгахын тулд төсвийн тодотгол хийнэ ээ гэсэн үг.

Тэгэхээр төсвийн тодотгол хийхдээ нэгэнт төсвийн тодотгол хийхээр болж байгаа юм чинь бас орлогоо тодотгох, зарлагаа тодотгох. Энэ хямралт нөхцөл байдлыг даван туулахын тулд тодорхой гарц шийдлүүд хийх энэ талдаа илүү анхаараасай.

Нэгэнт нэгэнт энэ хуульд орж ирж чадахгүй байгаа. Бид сая энэ хуулиар үндсэндээ гурил, мах, шатахууны үнийн хангамжийг тасалдуулахгүй байх, үнийг нь өсгөхгүй байх бодлого ирж байгаа.

Тэгвэл цаана нь нөгөө элсэн сахар, будаа, эм, эмнэлгийн хэрэгсэл зэрэг стратегиас ач холбогдолтой бүтээгдэхүүнүүд байж байгаа. Эдгээр хангамжийг тасалдуулахгүй байх, нөөцийг бүрдүүлэх, үнийг өсгөхгүй байх бодлогын асуудлыг төсвийн тодотгол оруулж ирэхдээ энэ гарц шийдлийг оруулж ирэх хэрэгтэй байна.

Орлого нэмэгдэх бололцоогүй байгаа. Сая С.Одонтуяа гишүүний ярьж байгаатай санал нэг байгаа. Явал нүүрснийхээ экспортыг нэмэгдүүлэх вэ. Энэ дээр бүхий л нөөц бололцоогоо шавхаж, одоо бүхий л юу гэдэг юм арга хэмжээг авмаар байгаа юм. Энэ талдаа илүү анхаарах хэрэгтэй байгаа.

Энэ хямралтай нөхцөл байдлыг бас ард иргэдийг, аж ахуй нэгж байгууллагыг илүү хүндрүүлэхгүй байхын тулд тодорхой зардал, татварыг хөнгөлөх энэ асуудлыг бид ярих ёстой. Онцгой нөхцөл байдалтай холбогдуулаад нэмэгдсэн өртгийн албан татвараа бид 50 хувь бууруулдаг юм уу, 5 хувь болгодог юм уу? Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хүн амын орлогын албан татварыг нэг 5 хувь болгодог юм уу? Нийгмийн даатгалын шимтгэлийг түр хугацаанд юм уу, нэг жилийн хугацаатай бууруулдаг юм уу.

Иймэрхүү байдлаар бас нэг тодорхой ачааг ард иргэдийнхээ нуруун дээрээс төр үүрэх. Төр үүрэхэдээ энэ эрсдэлийг хэрхэн яаж зохицуулах вэ. Даах. Засгийн газрын бонд гадаад дотоодоос босгох. Энэ байгалийн баялаг нүүрсээ урьдчилж зарж мөнгө босгох иймэрхүү одоо юу гэдэг юм орлогоо нэмэгдүүлж, зардлаа бууруулах, үүнийхээ үр дүнд аж ахуйн нэгж, иргэдээ эрсдэлээс хамгаалах. Энэ иргэдийнхээ, аж ахуйн нэгжийнхээ энэ хүндрэлтэй учраад байгаа, нүүр тулаад байгаа, ачаа үүрэх гээд байгаа энэ ачааг нь хөнгөлж өгөх ийм бодлогын асуудлуудыг төсвийн тодотгол хийхдээ оруулж ирэх ёстой шүү. Энэ тал дээр илүү анхаараарай. Хуульд нийцүүлж өөрчилж байгаад дэмжиж байна. Үндсэн хууль болон төсвийн тухай хуульд нийцүүлж энэ заалтыг өөрчилж байгааг дэмжиж байгаа. Ингэхдээ төсвийн тодотгол зайлшгүй хийж таарах нь. Ингэхдээ саяын ярьсан асуудлуудыг илүү анхаараарай гэдгийг Сангийн сайд болон холбогдох Засгийн газарт хэлье.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

31 гишүүн дэмжиж, 58.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Долоо. Төслийн 6.1.3 дахь заалтыг хасах. Санал хураалт.

35 гишүүн дэмжиж, 64.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм. Төслийн 6.1.5 дахь заалтыг хасах. Санал гарсан Ажлын хэсэг. Санал хураалт.

33 гишүүн дэмжиж, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ес. Төслийн 6.1.1, 7.1.1 дэх заалтын “бүтээгдэхүүний” гэсний дараа “үнийн өсөлт,” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

30 гишүүн дэмжиж, 55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арав. Хууль, тогтоолын хүчин төгөлдөр болох хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс гэж өөрчлөх.

Санал гарсан Ажлын хэсэг. Санал хураалт.

29 гишүүн дэмжиж, 53.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын санал.

1.Төслийн гарчигт “төрлийн” гэсний дараа “зарим” гэж, 5.1, 6.1, 7.1, 8.1 дэх хэсгийн “хэрэгжүүлнэ;” гэсний өмнө “авч” гэж, 5.1 дэх хэсгийн “гол” гэсний өмнө “энэ хуульд заасан” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 3.1 дэх хэсгийн “эдгээр бүтээгдэхүүнтэй хамаатай” гэснийг “эдгээртэй холбогдсон” гэж, 3.2 дахь хэсгийн “доор дурдсан” гэснийг “заасан гол нэр төрлийн зарим” гэж, мөн хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүнд дараах бараа, бүтээгдэхүүн” гэж, 7, 8 дугаар зүйлийн гарчгийн “байгууллагын” гэснийг “байгууллагаас” гэж, 8.1.1, 8.1.2 дахь заалтын “хуульд заасан зохицуулалтад хамрагдсан” гэснийг “хуулийн 3.2.2, 3.2.3-т заасан” гэж, 8.1.1 дэх заалтын “хүнсний хангамж,” гэснийг “хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, хангамж” гэж, 7.1.2, 8.1.2 дахь заалтын “мөрдүүлэх” гэснийг “, биелэлтийг ханган ажиллах” гэж, 6.1.6 дахь заалтын “мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.” гэснийг “, биелэлтийг хангуулан ажиллах” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн зүйл, хэсэг, заалт хасагдсантай холбогдуулан дугаарлалтыг өөрчлөх болон төслийн агуулгыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

33 гишүүн дэмжиж, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Эрхэм гишүүд ээ, Эдийн засгийн байнгын хорооны дарга, гишүүд, ажлын хэсгийн ахлагч нар аа.

Энэ хуулийн төслийн талаар “**D-Parliament**” цахим сүлжээгээр ирсэн саналуудыг багцалж энэ хэлэлцүүлгийн явцад анхаарах чиглэлийг өгч байна.

Энэ дотор үйлдвэрлэгч нарт хөнгөлөлттэй зээл, хөнгөлөлтийг өгөхдөө одоо байгаа үнийг тодорхой хувиар буулгах, тэр үнийг тодорхой хугацаанд барих шаардлага тавьж хөнгөлөлтийг олгох нь зүйтэй. Шууд олгох аваас зуршил болсон хэдэн хүнийг тэжээсэн үйлдэл болно шүү гэсэн. Ийм санал ирсэн.

Тэгээд үүний дагуу өнөөдөр Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд, Төмөртоогогийн Энхтүвшин бид нар энэ үндэсний үйлдвэрлэгч нартай уулзалт зохион байгуулсан. Үнийг буулгах санал тавьж хэлэлцүүлэг хийсэн. Энэ дээрээс гурван чиглэлийг ажлын хэсэгт өгч байна.

Нэгдүгээрт, Мах үйлдвэрлэгч нар нийслэл квотоо нэмэгдүүлэх, зохицуулалтын ажил хийх тохиолдолд хүнсний талоны зарчмаар болон бусад зарчмаар махаа бөөнд нийлүүлээд 1000 хүртэл төгрөгөөр буулгаж болно гэсэн.

Хоёрдугаарт нь, Гурил үйлдвэрлэгчдийн холбоо НӨАТ-аас чөлөөлөх юм бол 10.0 хувь буулгаж болно гэсэн.

Би үүнийг сая Сангийн сайдтай зөвлөлдсөн. Энэ бол нөгөө бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс чөлөөлөгддөг ийм нөгөө дотоодын улаан буудайгаар үйлдвэрлэсэн гурилыг чөлөөлнө гэсэн ийм заалтууд бас байна.

Тэгээд үүнийгээ нэг зохицуулалт хийгээд ажлын хэсэг Сангийн яаман дээрээ яриад, хэрвээ систем тохиргоон дээрээ болбол энэ замаар энэ гурил, махныхаа үнийг хямдруулчихаар байна.

Тэгвэл ард түмэнд ядаж бодитой тийм жишээ өгмөөр байна. Өнөөдөр Гурил үйлдвэрлэгчдийн холбоо, Тариаланчдын холбоо, тэгээд сүү, мах үйлдвэрлэгчдийн холбоотой уулзаж бид нар нэлээн ярилцлаа. Саналыг нь авлаа.

Цахилгааны үнэ 3-аас 5 хувь байна. Өнгөрсөн жил хэрэгжүүлж байсан зарчмаар хүнсний үйлдвэрлэгчдийг цахилгааны хөнгөлөлт үзүүлэх, цахилгааны төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх замаар 3-аас 5 хувь хүртэл бууралт хийх бололцоо байна. Үүнийг ажлын хэсэг авч хэлэлцээд тодорхой бууралт хийвэл сайн байна.

Одоо тэртээ тэргүй Эрдэнэт дээр буулт хийж байгаа тэр зарчим үйлчилж байгаа учраас ингэж нөгөө иргэд дээр учирч байгаа дарамтаа бууруулах, бодит үр дүн гаргахгүй болбол. Мах бол энэ жил онд мал сайн орсон.

Манай хөдөөнөөс сонгогдсон гишүүд, нэн ялангуяа Ж.Батжаргал гишүүн, Г.Ганболд гишүүдтэй ярьж байгаад энэ махны нийлүүлэлтийн байдал ямар болох нь вэ энэ тэртэй уялдаж байгаад, махныхаа зээлтэй уялдуулж байгаад.

Мах үйлдвэрлэгчдийн холбоо бол эхний ээлжид 300-гаас 600, тэгээд зарим дотаци нь шийдэгдвэл 1000 төгрөгөөр бууруулчихъя гэж байна. Энэ бол бас их том. Энэ хүнд үед бололцоо болно. Гурилын үнэ энэ хоёр. Мах, гурил хоёрынхоо үнийг ямар ч байсан бууралт хийхгүй бол хууль батлаад үр дүн гарахгүй бол болохгүй.

Тийм учраас яг үйлдвэрлэгч нартай нь ингээд тулж ажиллаж ярилцаж үзэхэд уриалга дэвшүүлэн ажиллая гэсэн юм ярьж байна шүү.

Бас нэг онцгой анхаарах юм байна. Одоо бензиний үнэ 10 төгрөгөөр нэмэгдэхэд жишээлбэл такси 100 төгрөгөөр нэмэгдчихдэг. Далимдуулж байгаа юмнууд байна.

Одоо энэ махыг энэ Мах үйлдвэрлэгчдийн холбоо ярьж байна. Махыг дэлгүүрүүдэд нийлүүлдэг, дэлгүүрүүдийн газар болгоны дэргэд цайны газартай болсон. Цайны газартаа энэ нөөцийн хямд махыг аваад гуанз, ресторанууд авчихдаг. Ингээд нөгөө ард иргэддээ хүрдэггүй.

Ийм юмнуудыг Шударга бус өрсөлдөөнийг зохицуулах газар хяналт тавьж ажиллах заалтыг Нийслэл, холбогдох байгууллагад хяналт тавьж ажиллахыг бас чиглэл болгомоор байна. Дайны сургаар дажин гэгчээр далимдуулж энэ төр, засгийн хөнгөлөлттэй бодлогыг мушгин гуйвуулдаг ийм зарчмыг өөрчилмөөр байна.

Тэгээд бас нэг зүйл хэлмээр байгаа юм. Ер нь бидний хэлсэн үгийн санал бол энэ олон улсын нөхцөл байдал хүнд байна. Тэгээд экспортоо дэмжье, импортоо хэмнэе гэж хэлсэн шүү дээ. Төр, засагч гэсэн, ард нийтээрээ ч гэсэн бас хэмнэлтийн горим хэрэгжүүлье. Энэ цахилгаанаа хэмнэж болно. Валют хэмнэнэ. Импортоо хэмнэж байж л бид энэ архи, дарснаас авхуулаад архины импортын татварын асуудал ярьсан шүү дээ.

Тэгээд үүнийг л зөвхөн нэг үгийг нь таслаад л ард нийтээрээ хэмнэе гэсэн. Ард нийтээрээ хэмнэе гэж хэлээгүй. Бүтэн үгээр нь үзвэл. Ингээд мушгин гуйваад л ард иргэдийг турхирч буруу ойлголт өгч байгаа юмнуудтай ч гэсэн бас бид нэгдсэн ойлголт өгч ажиллаж баймаар байна.

Ингээд энэ хүндрэлийг даван туулахын тулд импортоо хэмнэх хэрэгтэй. Экспортоо дэмжих хэрэгтэй. Төсвийн зардлуудаа хэмнэж төсвийн тодотгол хийх хэрэгтэй. Бас бүх шатандаа халамжийг ч гэсэн хэмнэх хэрэгтэй.

Яг шаардлагагүй хүнд халамж үзүүлэх байдаг юм уу. Хэмнэлт хийх маш их боломж байна гэдгийг бас бодох хэрэгтэй байгаа юм. Энэ санаануудыг л. Том оврын машин илүү бензин зарцуулаад байгаа учраас, импортыг дэмнээд байгаа учраас хэмнэе гэсэн ийм л санаанууд шүү дээ.

Тэгээд үүнийг бас аль болохоор хамтын хүчээр энэ хямралыг даван туулахын тулд нэгдсэн нэг зөв ойлголттой байх нь зүйтэй юм шүү гэдгийг ажлын хэсэг энэ хууль дээрээ бас анхаараад нэмээд суулгачихмаар байна.

Бас нэмэлт хоёр, гурван санал байгаа. Ирсэн. Тэрнийг би бичгээр өгье.

Тэгээд Үйлдвэрлэгчдийн холбооны үнэ бууруулах саналыг албан бичгээр авсан байгаа. 3 саналыг. Сүүн дээр ч гэсэн бас.

Тэгээд үүнийг ажлын хэсэгт өгье. Үүнийг маргааш өглөө хэлэлцээд эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарах чиглэлийг өгч байна. /алх цохив/

Монголбанк бас зээлийн бодлогоо уян хатан болгох. Тэгээд сүүлд нь бас л нэг энэ нэг баахан хэрүүл шуугиан болох. Хөгжлийн банк шиг болохгүй байх юмнуудыг сайн бодолцож яваарай. Тэгээд сүүлд нь тэгээд л бас тэгчихлээ ингэчихлээ гээд л. Үнэ тогтворжуулах хөтөлбөр шиг юм болов оо. Үүнийхээ хяналт, зохион байгуулалтыг сайн хэрэгтэй шүү.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томилолоор санал хурааж дууслаа.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Маргааш 09.00 цагаас Эдийн засгийн байнгын хороо хуралдана.

Саяын ярьсан асуудлыг Байнгын хороогоор авч хэлэлцээд.

Ажлын хэсэг тэр 3 санал өнөөдөр ирсэн байгаа. Би танд өгчихье. Бичгээр авсан байгаа. Би бас тэрийг сая.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД